



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/111

Бодь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2022 оны 02 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хууль журамд заасан хугацаанд татвар хураамжийг төсөвт төвлөрүүлэх, Үндэсний Их баяр наадмаар Монгол Улсын начин цол хүртсэн Э.Батмагнайд хүндэтгэл үзүүлэх, цаг үеийн мэдээ мэдээллийг ард иргэдэд хүргэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний тооцооллыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үндэсний Их баяр наадмаар Монгол Улсын начин цол хүртсэн Э.Батмагнайд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачилагатай оролцохыг сумын нийт малчид, ард иргэд, төрийн албан хаагч нарт уриалсугай.


3.Багт ажиллах үеэр архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглож, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах, цаг агаарын байдал муудаж, хүндэрч болзошгүй тул дулаан хувцас, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж аливаа эрсдэл гарахаас сэрэмжилж ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ

642201217



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

### Уубулан 1 дүгээр баг

Ахлагч: Д.Амар-Амгалан (ИТХ-ын дарга)-/зөвшилцсөнөөр/

Гишүүд: Ж.Лхагвасүрэн (багийн Засаг дарга)

Н.Хорлоо (Газрын даамал)

### Хүйс 2 дугаар баг

Ахлагч: Н.Сумъяа (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Наранбаатар (багийн Засаг дарга)

Э.Энхмаа (бага эмч)

О.Баасанбат (Нийгмийн даатгалын байцаагч)

### Хөнөг 3 дугаар баг

Ахлагч: Т.Эрдэнэцэцэг (Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн)

Гишүүд: У.Батцэцэг (багийн Засаг дарга)

Г.Оюунсүрэн (Татварын улсын байцаагч)

Б.Алтанхуяг (Малын бүртгэл, технологи хариуцсан мэргэжилтэн)

### Цагаан ус 4 дүгээр баг

Ахлагч: З.Цэрэндорж (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Б.Мөнхбат (багийн Засаг дарга)

Б.Мөнхжаргал (багийн эмч)

### Бодь 5 дугаар баг

Ахлагч: Б.Ганцэцэг (багийн Засаг дарга)

Гишүүд: С.Ганцэцэг (байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Б.Хандсүрэн (Нийгмийн бодлогын ажилтан)

10 Сумын Засаг даргын 2022 оны  
... дугаар сарын ... өдрийн ... тоот  
захирамжийн нэгдүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН НАЧИН Э.БАТМАГНАЙД ХҮНДЭТГЭЛ  
ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГ ТУС БҮРЭЭС  
ХАНДИВ ЦУГЛУУЛАХ ТООЦООЛОЛ

№	Багуудын нэрс	Хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа		
		Хонь	Унагатай гүү	Иргэд, төрийн албан хаагчид
1	Уубулан 1 дүгээр баг	40	1	50000 төгрөгнөөс дээш байх
2	Хүйс 2 дугаар баг	40	1	
3	Хөнөг 3 дугаар баг	40	1	
4	Цагаан ус 4 дүгээр баг	70	1	
5	Бодь 5 дугаар баг	40	1	

oOo